



Захиргааны нэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 01 сарын 10 ны
өдрийн 4622 дугаарт бүртгээ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 441

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн гадаад валютын үйл ажиллагааг дагнан эрхлэхээс бусад банк бус санхүүгийн үйл ажиллагаа шинээр эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 2,500,000,000 /хоёр тэрбум таван зуун сая/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 600,000,000 /зургаан зуун сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2. Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан шинээр эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 300,000,000 /гурван зуун сая/ төгрөг, аймаг сумдад 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

3. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдэд банк бус санхүүгийн итгэлцэл, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нэмж олгохдоо энэхүү тогтоолын 1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан банк бус санхүүгийн байгууллагад олгосугай.

5. Улаанбаатар хотод хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ 1,400,000,000 /нэг тэрбум дөрвөн зуун сая/, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумаас бусад аймаг, сумдад 100,000,000 /нэг зуун сая/ төгрөгт хүргээгүй банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргэхийг банк бус санхүүгийн байгууллагуудын хувьцаа эзэмшигч нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 271, 2017 оны 27 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

00471


7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН


Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 12-р сарын 27 өдрийн
441 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ
НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭГ
ҮЕ ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

Огноо	Улаанбаатар хот	Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад	/сая төгрөгөөр/
			Бусад аймаг, сумдад
2021.02.10	1,900.0	475.0	145.0
2022.02.10	2,500.0	600.0	200.0

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 2-р сарын 27 өдрийн
441 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААГ ДАГНАН ЭРХЭЛЖ БУЙ
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ
НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭГ ҮЕ
ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

/сая төгрөгөөр/

Огноо	Улаанбаатар хот	Бусад аймаг, сумдад
2020.02.10	200.0	100.0
2021.02.10	300.0	200.0